









АГУУЛГА

	Бүртгэлтэй ажилгүйчүүд
	Эрүүл мэнд
	Банк
	Төсөв
	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ
	Хөдөө аж ахуй
	Аж үйлдвэр
	Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж хауй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 оны 08 дугаар сарын байдал)

Бүртгэлтэй ажилгүй иргэн


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 8 дугаар сарын байдлаар 774 байгаагийн 55.9 хувь нь буюу 433 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 12 хүнээр буюу 1.5 хувиар буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнөөр нь авч үзвэл 274 нь дээд, 34 нь тусгай дунд, 65 нь техник мэргэжлийн, 339 нь бүрэн дунд, 43 нь суурь, 13 нь бага, 6 нь ямар ч боловсролгүй байна хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 8 сарын эцэст




Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2018 оны эхний 8 сарын байдлаар




Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2018 оны 08 сарын байдлаар 848 эх амаржиж 857 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 15, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгджээ.




Цочмог халдварт өвчин 357 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 37.6 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчний 28 хувийг салхинцэцэг, 8 хувийг гар хөл амны өвчин, 33 хувийг БЗХӨ, 10 хувийг хачигт реккетиоз, 21 хувийг бусад халдварт өвчин эзлэж байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2018 оны 8 сарын байдлаар




Төсвийн орлого

Аймгийн төсөвт нийт 5 тэрбум 459.2 сая төгрөг хүрч, төлөвлөгөөг 116.9 хувиар, үүнээс татварын орлого 3 тэрбум 955.9 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 111.4 хувиар биелүүлсэн байна.

Татварын бус орлого 441.6 сая төгрөг төлөвлөгөөг 132.9 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1 тэрбум 22.6 сая төлөвлөгөөг 132.3 хувиар давуулан биелүүлсэн байна.


Төсвийн орлогын бүтэц, мянган төгрөгөөр 2018 оны VIII сард



Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 85.6 хувийг зарцуулав. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 87.5 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 94.8 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 91.9 хувь, хангамж, бараа материалын зардлын 87.3 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Орон нутгийн төсвийн байгууллагууд 20.2 сая төгрөгийн авлагатай, 350.4 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Орон нутгийн зарлага санхүүжилт түүний эзлэх хувь




Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2018 оны 8 дугаар сард өмнөх сараасаа 0.3 хувь, өмнөх оны жилийн эцсээс 5.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувиар өссөн байна. Ерөнхий индекс 2018 оны 8 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ бүлгийн индекс 27.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018-08 2017-08	2018-08 2017-12	2018-08 2018-07
Ерөнхий индекс	100.0	106.2	105.6	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	107.9	109.0	90.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	110.7	110.5	100.4
Хувцас, бөс бараа, гутал	16.1	102.7	100.6	99.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.8	102.2	100.7
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	101.6	100.8	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	107.4	102.9	99.2
Тээвэр	12.2	104.0	106.3	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	98.8	98.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.2	100.2	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	127.4	127.4	127.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	102.6	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	100.1	99.9	99.1

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2018 оны 8 дугаар сард өмнөх оны жилийн эцсээс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус 9.0, хувцас, бөс бараа, гутал 10.5, боловсролын үйлчилгээний индекс 27.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2018 оны 8 дугаар сард аймгийн төв болох Есөнбулаг суманд ямааны ноолуур 90.0 мянган төг, адууны дэл, сүүл 10.0 мянган төг, хонины арьс 2.0 мян.төг, ямааны арьс 2.0 мян.төгрөгний үнэ ханштай байна.

Хөдөө аж ахуй


Аймгийн дүнгээр төллөх насны хээлтэгчийн 56.9 хувь болох 862.0 мянган толгой хээлтэгч мал төллөж, 844.8 мянган төл 98.0 хувиар бойжиж байна. Төлийн хорогдол 17474 гарсан ба төрлөөр нь авч үзвэл 399 унага, 507 тугал, 142 ботго, 5193 хурга, 11233 ишиг тус тус хорогджээ.

8 сарын байдлаар аймгийн хэмжээнд 129.7 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.3 дахин их байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1356, үхэр 2252, тэмээ 184, хонь 31767, ямаа 94117 байна. Нийт хорогдлын 24.5 хувийг хонь, 72.6 хувийг ямаа эзэлж байна.


Төллөсөн хээлтэгч, жил бүрийн 8 сарын байдлаар




Гарсан төл, жилийн бүрийн 8 сарын байдлаар



Хорогдсон төл, жил бүрийн 8 сарын байдлаар




Бойжсон төл, жил бүрийн 8 сарын байдлаар




Газар тариалан

Энэ сарын байдлаар үр тариа 16.7 тн, төмс 139.3 тн, хүнсний ногоо 111,23 тн, малын тэжээлийн ургамал 294.4 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн 183.3 тн байгалийн хадлан, 325 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

Том малын зүй бусын хорогдол, төрлөөр, жил бүрийн 8 сарын байдлаар




Том малын зүй бусын хорогдол, төрлөөр, жил бүрийн 8 сарын байдлаар



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл энэ сард 6 тэрбум 7.6 сая төгрөг, үүнээс 41.8 хувийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, 28.0 хувийг дулаан эрчим хүч үйлдвэрлэл, 6.3 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 10.9 хувийг нүүрс олборлолт, 12.9 хувийг усан хангамжийн салбар тус тус эзэлж байна. Нийт 7 тэрбум 1148.0 төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, 2018 оны 8 сарын байдлаар, салбараар, эзлэх хувь



Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2018 оны 8 дугаар сарын эцэст 97.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 22.0 тэрбум төгрөг буюу 29.1 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	2018-VIII	
	2017-VIII	2018-VIII
Мөнгөний нийлүүлэлт M2	75593.1	97594.2
Сарын өөрчлөлт, хувиар	19.9	29.1
Нийт хадгаламж	64791.4	80622.0
Сарын өөрчлөлт, хувиар	20.4	24.4
Төгрөгийн хадгаламж	64662.7	80411.7
Сарын өөрчлөлт, хувиар	21.1	24.4
Валютын хадгаламж	128.7	210.3
Сарын өөрчлөлт, хувиар	-70.2	63.4


Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 1 тэрбум 977.0 сая төгрөг болж, өмнөх оноос 680.5 сая төгрөг буюу 25.6 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 8 дугаар сарын эцэст 108.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 21.7 тэрбум төгрөг буюу 25.1 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 8 дугаар сарын эцэст 592.6 сая төгрөг болж, өмнөх оноос 57.9 сая төгрөг буюу 10.8 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.6 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл 2018 оны 8 дугаар сарын эцэст 1.0 тэрбум төгрөг болж өмнөх оноос 610.9 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.


Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг



Цахилгаан холбоо


Суурин телефон цэгийн тоо 378, холбооны газрын орлого 140.6 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 98.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг



■ 2017 оны VIII сард ■ 2018 оны VIII сард


Суурин утасны цэгийн тоо



■ 2017 оны VIII сард ■ 2018 оны VIII сард

Говь-Алтай аймгийн 2018 оны IX сарын цаг агаарын урьдчилсан төлөв


Агаарын температурын сарын дундаж нь Алтайн уулархаг нутгаар 4-9 градус, Алтайн өвөр говиор 14-19 градус, бусад нутгаар 9-14 градус дулаан Говь-Алтайн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна(3 дугаар зураг).



3 дугаар зураг. 9 дүгээр сарын температурын урьдчилсан мэдээ

Нэг болон хоёрдугаар арав хоногийн эхний хагаст Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 1-6 градус, өдөртөө 15-20 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 11-16 градус, өдөртөө 26-31 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 20-25 градус дулаан байна. Нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр сэрүүсч Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн цочир хүйтэрнэ, өдөртөө 8-13 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 7-12 градус, өдөртөө 18-23 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 7-12 градус хүйтэн өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 2-7 градус хүйтэн өдөртөө 8-13 градус дулаан байна. Бусад хугацаанд Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 7-12 градус, өдөртөө 22-27 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 2-7 градус өдөртөө 17-22 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Говь-Алтайн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас бага, Говь-Алтай өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байна(4 дүгээр зураг).



4 дүгээр зураг. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан мэдээ

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар бороо, уулархаг нутгаар хур тунадас орно. Дуу цахилгаантай.

Хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн хойд хэсгээр хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар түр зуур 16-18 м/с хүрч ширүүснэ. Хоёр ба гуравдугаар арав хоногийн эхээр болон гуравдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 18-20 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШГ-ын УМХ

**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшингээр	By educational level	2014.XII	2015.XII	2016.XII	2017.XII	8-сар In July	
						2017	2018
Бүгд	Total	1241	1044	786	796	753	774
Үүнээс: эмэгтэй	of which:female	699	547	435	430	410	433
Дээд боловсролтой	Higher education	327	252	265	280	233	274
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	477	72	35	49	30	34
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	37	81	70	66	67	65
Бүрэн дунд	Upper secondary school	270	483	341	331	335	339
Суурь	Compulsory secondary school	87	112	42	41	54	43
Бага	Primary school	34	35	28	27	29	13
Боловсролгүй	Uneducated persons	9	9	5	2	5	6

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2018 оны 8-р сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of August 2018**

Үүнээс:насны бүлгээр of which:by age group

Сар Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	15-24	25-34	35-44	45-59	55-59	60+						
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female						
I	956	510	214	128	342	182	202	105	155	73	29	14	14	8
II	731	399	170	99	272	148	155	85	106	52	17	9	11	6
III	829	465	193	111	314	177	170	99	120	59	21	13	11	6
IV	878	539	174	104	352	213	200	133	119	68	20	13	13	8
V	800	508	184	109	294	191	192	124	105	67	19	13	6	4
VI	974	606	232	130	352	217	224	151	133	85	25	17	8	6
VII	807	485	218	123	300	180	170	109	95	58	19	12	5	3
VIII	774	433	208	109	278	161	159	96	101	55	20	7	8	5

2018 ОНЫ 8 САРД АЖИЛД ОРСОН ХҮН

NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 8 months of 2018

Сар Month	Бүгд Total	Төрийн өмчит үйлдвэрийн газарт	Төрийн төсөвт байгууллагад Government organization	Компани Company	Хоршоо Cooperative	Бусад Other
I	46	-	1	45	-	-
II	9	-	-	8	-	1
III	34	-	10	23	-	1
IV	62	1	40	14		7
V	67		33	31		3
VI	78		71	3		4
VII	242		135	81		26
VIII	4			4		

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМДААР
NUMBER OF UNEMPLOYED, by som

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2014.XII	2015.XII	2016.XII	2017.XII	8-р сар		
						in August		
						2017	2018	2018%
Есөнбулаг	Yesunbulag	488	284	326	353	270	359	133.0
Алтай	Altai	11	40	10	27	16	14	87.5
Баян-Уул	Bayan-Uul	12	22	40	28	35	40	114.3
Бигэр	Biger	23	56	35	24	30	19	63.3
Бугат	Bugat	33	26	19	31	17	20	117.6
Дарив	Darib	32	47	17	12	7	18	257.1
Дэлгэр	Delger	29	45	44	75	62	30	48.4
Жаргалан	Jargalan	26	33	11	6	8	13	162.5
Тайшир	Taishir	10	17	15	16	19	14	73.7
Тонхил	Tonhil	38	68	20	11	22	26	118.2
Төгрөг	Tugrug	18	37	21	16	23	14	60.9
Халиун	Haliun	16	35	25	30	35	30	85.7
Хөхморьт	Huhmorit	12	15	34	16	34	10	29.4
Цогт	Tsogt	40	73	61	63	58	44	75.9
Цээл	Tseel	22	37	15	16	21	44	209.5
Чандмань	Chandmani	16	75	34	45	60	31	51.7
Шарга	Sharga	27	46	34	12	35	23	65.7
Эрдэнэ	Erdene	11	25	25	15	24	25	104.2
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	373	63	-	-	-	-	-
ДҮН	TOTAL	1237	1044	786	796	776	774	99.7

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
PUBLIC HEALTH OF POPULATION

№	Сумын нэр	Soum	төрсөн эх <i>Women who gave births</i>		эхийн эндэгдэл <i>Maternal Deaths</i>		төрсөн хүүхэд <i>Births</i>		Нялхасын эндэгдэл <i>Infant mortality</i>		1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл <i>Under-five mortality</i>		Нийт нас баралт <i>Deaths</i>		Эмнэлэгт нас баралт <i>Deaths</i>	
			2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	696	787	0	0	701	797	11	10	2	0	81	71	24	14
2	Алтай	<i>Altai</i>	3	3	0	0	3	3	0	0	0	0	8	4	2	2
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>	12	4	0	0	12	4	0	0	0	0	8	15	0	3
3	Бигэр	<i>Biger</i>	6	4	0	0	6	4	0	0	0	1	9	6	1	0
4	Бугат	<i>Bugat</i>	1	3	0	0	1	3	0	0	0	0	10	3	3	3
5	Гуулин	<i>Gulin</i>	0	1	0	0	0	1	0	0	0	0	1	6	0	0
5	Дарив	<i>Darib</i>	6	6	0	0	6	5	0	1	0	0	2	8	1	3
6	Дэлгэр	<i>Delger</i>	5	3	0	0	5	3	1	0	0	0	6	8	3	0
7	Жаргалан	<i>Jargalan</i>	1	0	0	0	1	0	0	1	0	0	5	5	4	1
8	Тайшир	<i>Taishir</i>	0	0	0	0	0	0	0	1	0	0	2	3	0	0
8	Тонхил	<i>Tonhil</i>	5	7	0	0	5	7	1	0	0	1	5	14	1	3
9	Төгрөг	<i>Tugrug</i>	3	5	0	0	3	5	2	0	0	1	8	6	5	1
10	Халиун	<i>Haliun</i>	2	1	0	0	2	1	0	0	0	0	1	9	0	1
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>	0	2	0	0	0	2	0	0	0	0	7	10	2	4
11	Цогт	<i>Tsogt</i>	6	4	0	0	6	3	0	1	0	1	5	10	2	3
12	Цээл	<i>Tseel</i>	3	5	0	0	3	6	0	0	0	0	3	8	0	1
12	Чандмана	<i>Chandmani</i>	8	5	0	0	8	5	0	1	0	0	3	5	2	2
13	Шарга	<i>Sharga</i>	0	1	0	0	0	1	0	0	0	0	6	2	0	0
14	Эрдэнэ	<i>Erdene</i>	10	7	0	0	10	7	0	0	0	0	7	1	1	0
15	Баянтоорой	<i>Bayantoroi</i>	1	0	0	0	1	0	0	0	1	0	2	6	1	2
22	Дүн	Total	768	848	0	0	773	857	15	15	3	4	179	200	52	43

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд Infectious Diseases		Үүнээс: Of which:															
			БЗХӨ STID										Гепатит Hepatite		Сүрьеэ Tuberculosis		Улаан бурхан		бусад Other	
			трихоминаз Trichimoniasis		тэмбүү Syphilis		заг хүйтэн Gonorrhea													
			2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018		
1	Есөнбулаг	Yesunbulag	363	235	7	11	44	27	8	9	1		2	3			301	185		
2	Алтай	Altai	7	4			5	4	1		0						1	0		
3	Баян-Уул	Bayan-Uul	10	5			5	2	1		1		1	1			2	2		
3	Бигэр	Biger	17	5			1	3.0		1	0						16	1		
4	Бугат	Bugat	8	17			3	8	1		0	1					4	8		
5	Гуулин	Gulin	6	1							0						6	1		
5	Дарив	Darib	3	1		1	1				0						2	0		
6	Дэлгэр	Delger	19	12	1			2.0	1	2	0	1	2	1			15	6		
7	Жаргалан	Jargalan	12	2			1	1			0						11	1		
8	Тайшир	Taishir	13	5	1			1	2		0		1				9	4		
8	Тонхил	Tonhil	2	3							0						2	3		
9	Төгрөг	Tugrug	1	11		1		9	1		0						0	1		
10	Халиун	Haliun	15	11			2	4	1		0						12	7		
10	Хөхморьт	Huhmorit	18	10	1	1	13	5		1	0			1			4	2		
11	Цогт	Tsogt	3	7		2	1			2	0						2	3		
12	Цээл	Tseel	11	7		1	2	4			0						9	2		
12	Чандмана	Chandmani	12	3			4	1			1		1				6	2		
13	Шарга	Sharga	21	4			5	1	1	1	0		3				12	2		
14	Эрдэнэ	Erdene	4	0			1				0		1				2	0		
15	Баянтоорой	Bayantoroi	16	0			2				0						14	0		
16	Харьяаллын бус		11	14	1	3	8	8	1	2.0				3			11	14		
22	Дүн	Total	572	357	11	20	98	80	18	18	3	2	11	9	0	0	441	244		

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	мян.төг <i>thous.tog</i>		
		Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
НИЙТ ОРЛОГО		4,668,931.2	5,459,184.1	116.9
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		3,895,792.6	4,436,586.7	113.9
1. ТАТВАРЫН ОРЛОГО		3,550,436.4	3,955,974.5	111.4
1.1 Орлогын албан татвар		2,822,884.9	3,087,276.7	109.4
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар		3,372,884.9	3,586,084.3	106.3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		2,782,675.1	2,714,272.7	97.5
Үйл ажиллагааны орлого		192,751.8	224,422.8	116.4
Хөрөнгийн орлого		285,212.0	554,333.5	194.4
Хөрөнгө борлуулсны орлого		48,500.0	48,516.3	100.0
Шууд бус орлого		63,746.0	44,539.0	69.9
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(550,000.0)	(498,807.6)	90.7
1.2 Хөрөнгийн албан татвар		390,389.4	443,323.9	113.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		129,353.4	154,992.7	119.8
Галт зэвсгийн албан татвар		25,356.0	23,470.6	92.6
татвар		235,680.0	264,860.6	112.4
Малд ногдуулах албан татвар		-	-	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж		337,162.1	425,373.9	126.2
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж		184,145.6	201,540.3	109.4
Улсын тэмдэгтийн хураамж		85,606.8	110,947.2	129.6
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		(6,000.0)	(2,618.7)	43.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		5,870.0	2,446.5	41.7
Хог хаягдлын хураамжийн төлбөр		98,668.8	90,765.3	92.0
1.3.2 Газрын төлбөр		102,996.5	122,382.0	118.8
Үүнээс: Газрын төлбөр		102,996.5	122,382.0	118.8
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		-	-	0.0
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		49,450.0	101,451.6	2 дахин
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		600.0	498.0	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		-	58,047.1	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		48,850.0	42,898.5	87.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр		-	8.0	0.0
1.3.4 Бусад татвар		570.0		0.0
2. ТАТВАРЫН БУС ОРЛОГО		332,356.2	441,617.2	132.9
Хүү, торгуулийн орлого		262,137.0	390,227.8	148.9
Төсвийн байгууллагын өөрийн орлого		23,026.4	27,302.4	118.6
Түрээсийн орлого		17,192.8	16,998.0	98.9
Бусад орлого		30,000.0	7,089.0	23.6
3. ХӨРӨНГИЙН ОРЛОГО		13,000.0	38,995.0	3 дахин
Өмч хувьчлалын орлого		13,000.0	38,995.0	3 дахин
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		773,138.6	1,022,597.4	132.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		86,540.0	108,274.0	125.1
НӨАТатвар		615,000.0	816,855.0	132.8
Онцгой албан татвар		22,506.4	34,100.0	151.5
Агаарын бохирдлын төлбөр		38,092.2	22,213.9	58.3
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		11000.0	41154.5	3 дахин

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

мян.мөг, thous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,663,566.7	35,654,542.1	85.6
НИЙТ ЗАРЛАГА	40,191,317.4	35,160,380.4	87.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,920,348.4	33,212,769.8	92.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,827,561.5	24,821,934.2	92.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,185,626.7	16,638,900.8	96.8
Үндсэн цалин	14,323,227.6	14,074,581.5	98.3
Нэмэгдэл	165,934.4	158,403.0	95.5
Унаа хоолны хөнгөлөлт	83,736.0	66,285.5	79.2
Урамшуулал	1,338,529.2	1,122,576.7	83.9
Гэрээт ажлын хөлс	1,274,199.5	1,217,054.1	95.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,084,088.4	1,976,022.4	94.8
Тэтгэврийн даатгал	1,377,598.4	1,391,811.1	101.0
Тэтгэмжийн даатгал	167,577.6	138,633.9	82.7
ҮОМШӨ-ний даатгал	140,394.6	120,593.4	85.9
Ажилгүйдлийн даатгал	55,685.4	41,574.2	74.7
Эрүүл мэндийн даатгал	342,832.4	283,409.8	82.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,930,063.7	2,692,283.9	91.9
Гэрэл, цахилгаан	294,378.9	264,315.9	89.8
Түлш, халаалт	2,529,923.5	2,344,934.5	92.7
Цэвэр, бохир ус	105,761.3	83,033.6	78.5
Хангамж, бараа материалын зардал	824,288.3	719,781.0	87.3
Бичиг хэрэг	92,778.3	77,902.4	84.0
Тээвэр, шатахуун	493,327.4	464,875.8	94.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	79,546.5	56,012.8	70.4
Ном, хэвлэл	22,372.7	10,281.8	46.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	49,452.4	36,470.9	73.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,811.0	74,237.4	85.5
Нормативт зардал	1,082,180.6	911,215.8	84.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	146,271.6	134,202.1	91.7
Хоол, хүнс	873,685.8	747,379.2	85.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,223.2	29,634.5	47.6
Эд хогшил, урсгал засварын зардал	774,341.5	467,556.3	60.4
Багаж, техник, хэрэгсэл	129,430.8	108,058.1	83.5
Тавилга	22,960.0	12,191.5	53.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,380.0	4,735.6	38.3
Урсгал засвар	609,570.7	342,571.1	56.2
Томилолт, зочны зардал	191,206.0	155,343.3	81.2
Дотоод албан томилолт	191,206.0	155,343.3	81.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,			
хураамж	1,310,909.5	890,354.9	67.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил			
үйлчилгээний төлбөр хураамж	1,245,920.6	846,412.9	67.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,990.0	7,176.4	79.8
Даатгалын үйлчилгээ	24,567.5	19,252.7	78.4
Тээврийн хэрэгслийн татвар	9,096.2	4,781.9	52.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,629.9	1,966.7	54.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,570.3	9,321.5	59.9
Газрын төлбөр	2,985.0	1,381.8	46.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150.0	61.0	40.7

Үргэлжлэл
мян.төг, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
Бараа үйлчилгээний бусад зардал	444,856.8	370,475.9	83.3
Бараа үйлчилгээний бусад зардал	371,700.4	321,727.5	86.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,156.4	48,748.4	66.6
ТАТААС	15,333.6	7,666.8	50.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15,333.6	7,666.8	50.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,077,453.3	8,383,168.8	92.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,920,606.0	3,906,013.0	99.6
Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,920,606.0	3,906,013.0	99.6
Бусад урсгал шилжүүлэг	5,156,847.3	4,477,155.8	86.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,586,133.6	3,209,435.2	89.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,072.2	3,022.2	98.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	264,284.8	250,964.0	95.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	361,825.0	276,550.9	76.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	569,465.0	542,886.7	95.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	372,066.7	194,296.8	52.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,270,969.0	1,947,610.6	45.6
Барилга байгууламж	4,270,969.0	1,947,610.6	0.0
Бусад хөрөнгө	1,472,249.3	494,161.7	33.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,472,249.3	494,161.7	33.6
Эргэж төлөгдөх зээл	41,663,566.7	39,522,208.1	94.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,387,580.7	21,347,491.7	99.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	21,387,580.7	21,347,491.7	99.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,461,103.3	17,185,885.8	93.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,115,234.4	14,885,278.9	92.4
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,345,868.9	2,300,606.9	98.1
ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ	1,814,882.7	279,632.1	15.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,182.5	204,027.5	356.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,010.8	75,070.8	220.7
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,723,689.4	533.8	0.0
ТӨСӨВ БОЛОН ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛСЭН ЗЭЭЛЭЭС ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ	0.0	709,198.5	0.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	4,479,285.0	0.0

ТАТВАРЫН ОРЛОГО ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE soum

№	Сум	Soum	мян.төг thous.tog		
			Нийт орлого		Gross income
			Төлөвлөгөө Project	Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	397,180.0	509,448.0	128.3
2	Алтай	Altai	15,020.0	37,902.7	252.3
3	Баян-Уул	Bayn-Uul	22,406.8	39,503.8	176.3
4	Бигэр	Biger	14,339.8	23,891.1	166.6
5	Бугат	Bugat	16,753.8	31,283.5	186.7
6	Дарив	Dariv	14,780.0	19,363.0	131.0
7	Дэлгэр	Delger	7,440.0	19,184.8	257.9
8	Жаргалан	Jargalan	12,392.8	25,305.7	204.2
9	Тайшир	Taishir	8,690.0	13,706.8	157.7
10	Тонхил	Tonhil	22,600.0	81,018.1	358.5
11	Төгрөг	Tugrug	20,120.0	33,134.8	164.7
12	Халиун	Khaliun	7,392.0	13,965.4	188.9
13	Хөхморьт	Khukhmorit	11,720.0	20,961.8	178.9
14	Цогт	Tsogt	18,310.0	23,832.8	130.2
15	Цээл	Tseel	18,774.0	38,442.4	204.8
16	Чандмань	Chandmani	18,460.0	24,788.0	134.3
17	Шарга	Sharga	10,784.0	21,003.1	194.8
18	Эрдэнэ	Erdene	19,100.0	24,211.8	126.8
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	5,698.0	13,813.6	242.4
20	Гуулин тосгон	Guulin	2,248.8	9,228.7	410.4
21	Татварын хэлтэс	Straight communicant	3,231,582.6	3,412,596.8	105.6
Дүн			3,895,792.6	4,436,586.7	113.9

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE *sum*

мян.мөг, thous.tog

№	Сум	Soum	Орон нутаг Provincial government		
			Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	6,863,133.1	6,533,068.1	95.2
2	Алтай	<i>Altai</i>	1,082,206.1	1,037,913.6	95.9
3	Баян-Уул	<i>Bayn-Uul</i>	1,026,390.6	893,684.8	87.1
4	Бигэр	<i>Biger</i>	1,022,962.4	887,147.8	86.7
5	Бугат	<i>Bugat</i>	1,132,837.2	983,160.0	86.8
6	Дарив	<i>Dariv</i>	1,094,083.2	945,757.1	86.4
7	Дэлгэр	<i>Delger</i>	1,220,341.0	1,085,126.2	88.9
8	Жаргалан	<i>Jargalan</i>	815,286.7	756,332.5	92.8
9	Тайшир	<i>Taishir</i>	930,056.5	847,303.1	91.1
10	Тонхил	<i>Tonhil</i>	1,301,066.7	907,308.2	69.7
11	Төгрөг	<i>Tugrug</i>	1,104,505.4	814,245.9	73.7
12	Халиун	<i>Khaliun</i>	1,107,085.8	967,412.1	87.4
13	Хөхморьт	<i>Khukhmorit</i>	1,150,219.8	994,930.1	86.5
14	Цогт	<i>Tsogt</i>	1,244,784.7	1,059,114.4	85.1
15	Цээл	<i>Tseel</i>	999,965.2	873,564.2	87.4
16	Чандмань	<i>Chandmani</i>	1,101,877.5	935,189.4	84.9
17	Шарга	<i>Sharga</i>	995,821.7	829,951.6	83.3
18	Эрдэнэ	<i>Erdene</i>	1,136,625.3	1,032,959.5	90.9
19	Гуулин тосгон	<i>Guulin</i>	596,666.2	539,489.1	90.4
20	Баянтоорой тосгон	<i>Bayntooroi</i>	704,886.3	633,675.3	89.9
21	Говь-Алтай аймаг шууд харилцагч	<i>Straight communicant</i>	15,032,765.3	12,097,209.0	80.5
Дүн			41,663,566.7	35,654,542.1	85.6

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН сумаар, оны үнээр
GROSS INDUSTRIAL OUTPUT, by soum, at current price

		мян.төг / thous.tug/			
Сум	Soum	2017.VIII	2018.VIII	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2017	2018
Нийт дүн	Total	7269578.2	6007661.3	105.63	100.00
Есөнбулаг	Yesunbulag	6948787.5	5293155.6	95.59	88.11
Алтай	Altai	37314.2	33878.0	0.51	0.56
Баян-Уул	Bayan-Uul	16390.6	14084.9	0.23	0.23
Бигэр	Biger	25840.9	24905.1	0.36	0.41
Бугат	Bugat	49955.2	61924.8	0.69	1.03
Дарив	Darib	145237.4	137653.1	2.00	2.29
Дэлгэр	Delger	22437.9	21048.0	0.31	0.35
Жаргалан	Jargalan	8675.5	9448.8	0.12	0.16
Тайшир	Taishir	102519.7	131097.5	1.41	2.18
Тонхил	Tonhil	18137.9	17130.0	0.25	0.29
Төгрөг	Tugrug	15760.8	15041.9	0.22	0.25
